



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/36

Аргатай

Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл
болон хяналтын зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 297 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”, Аймгийн Засаг даргын 2011 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн А/630 дугаар захирамжыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | |
|----------------------|--|
| Зөвлөлийн дарга | Сумын Засаг дарга |
| Нарийн бичгийн дарга | Эмийн эргэлтийн сангийн эрхлэгч |
| Гишүүдэд | Эрүүл мэндийн төвийн эрхлэгч |
| | Нийгмийн даатгалын байцаагч |
| | Нийгмийн бодлогын мэргэжилтэн |
| | Эмийн эргэлтийн сангийн нягтлан бодогч |
| | Иргэний төлөөлөл |

2. Эмийн эргэлтийн сангийн хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|--------|-----------------------------|
| Дарга | ИТХ-ын нарийн бичгийн дарга |
| Гишүүн | ЭМТөвийн ахлах сувилагч |
| | Иргэний төлөөлөл |

3. Сум багийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг тогтвортой байлгах зорилгоор эм эргэлтийн санг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд даалгасугай

4.Ард иргэдэд худалдаалж байгаа эмийн үнэ, эм эргэлтийн сангийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд хяналт тавьж ажиллахыг хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



О.УУГАНБААТАР